

МОНГОЛ УЛС БОЛООД ХБНГУ -ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА СОЁЛ БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ЖИШЭЭН ДЭЭР

Г.Гэрэлмаа¹

Монгол улс болоод өнөөгийн ХБНГУ хоорондын хамтын ажиллагааг 1240 оны үед Бат хаанаас 2-р Фредрик хаанд захидал хүргүүлж байсан тухай түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн баримтаас эхлэлтэй гэж үзвэл манай хоёр орны харилцааны түүх эдүгээ 800 шахам жилийн улбаатай ажээ. Энэхүү харилцаа нь цаг үеийн улс төр, нийгмийн ээдрээт амьдрал, нугачаанаас үүдэн нэг үе идэвхжин, нэг үе тасалдаж байжээ.

Хамгийн анхны харилцаа тогтоож байсан тэрхүү үеэс 21-р зууны эхэн хүртэл манай хоёр орны харилцаа хэрхэн хөгжиж байсан тухай түүхэн баримт материал хомс байдаг. Мөн 1938-1950 онд дэлхийн 2-р дайн болоод дайны дараах ЗХУ-ын үзэл баримтлалаас үүдэн манай хоёр орны харилцаа бүрэн зогсч байсан ажээ.

Хожмоо 1960-1990-ээд онд ХБНГУ нь БНАГУ, ХБНГУ хэмээн хуваагдан нийгмийн хоёр өөр замаар хөгжиж байсан түүхэн ээдрээт үед ч Монгол улс нь Герман улстай гүн гүнзгий итгэлцэлд тулгуурласан нягт хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж ирсэн байна. Тухайлбал БНМАУ нь 1950 онд БНАГУ-тай дипломат харилцаа тогтоосныхоо дараа ХБНГУ-тай мөн дипломат харилцаа тогтоохыг хүсэвч үндэсний язгуур эрх ашгаасаа түрүүнд “социалист хамтын нөхөрлөлийн орнуудын” гэх нэрээр бусдын ашиг сонирхлыг дээгүүр тавьдаг байсан тухайн цаг үеийн харамсууштай бодлогод баригдан өөрсдийн хүсэл сонирхлоо гүйцэлдүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгарч байжээ. ХБНГУ-ын тал ч мөн адил Монголтой дипломат харилцаа тогтоох сонирхлоо янз бүрийн суваг ашиглан илэрхийлж байсан тухай таамаглал байдаг. Энэхүү тэмцлийн эцэст БНМАУ, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох тухай 1973 оны 5 дугаар сарын 10-нд Лондон хотноо эхэлсэн хэлэлцээ бүтэн 8 сар гаруй үргэлжлэн 6 удаагийн хуралдааны дараа 1974 оны 1 сарын 22-нд Лондон хотноо өндөрлөжээ. БНМАУ, ХБНГУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох тухай баримт бичгүүдийг хоёр улсын засгийн газар баталсны дараа буюу 1974 оны 1 сарын 31-нд дипломат харилцаа тогтоосон тухай ноот бичгийг Лондон хотноо харилцан солилцож, мөн өдөр энэ тухай хоёр тал албан ёсоор нэгэн зэрэг олон нийтэд зарласнаар Монгол, ХБНГУ-ын албан ёсны харилцааны түүхэн эхлэл тавигдсан тухай манай ахмад дипломатч Л.Удвал гуай дурьдсан байдаг²

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш

² (Л.Удвал, Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны түүхэн эхлэл <http://www.mongolei-zentrum.de>)

Энэхүү үеэс өнөөдрийг хүртэл хэдэн арван жилийн уламжлалтай Монгол-Германы харилцаанд ихээхэн ахиц дэвшил гарч байгаа бөгөөд хоёр талын хамтын ажиллагаа нь иж бүрэн түншлэлийн хүрээнд улам бүр өргөжин тэлсээр байгааг Монгол улсын Гадаад харилцааны сайд Г.Занданшатар Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн ХБНГУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол-Германы Чуулганы бага хуралд оролцож хэлсэн үгэндээ онцлон тэмдэглэсэн байдаг.

Дэлхий нийтээрээ даяарчлагдаж буй өнөө үед аль ч улсын хөгжил дэвшил бусдынхаасаа хамааралтай болсон энэхүү нөхцөлд оршин буй байршил, эдийн засгийн үзүүлэлт зэргээс үл хамааран ядуу буурай болоод хөгжиж буй орнуудад туслах зорилгоор хөгжингүй гүрнүүдийн зүгээс хөгжлийн тусламжийн бодлого хэрэгжүүлэх нь нэгэнт хэвшил болжээ. ХБНГУ нь Монгол улсын гуравдагч хөрш бөгөөд Европ дахь хамгийн гол түнш орон юм. 1992 оноос хойш Монгол улсад Германаас техникийн болон санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд үзүүлсэн нийт тусламж дэмжлэгийн хэмжээ 244,7 сая евро болсон нь 380 сая орчим ам.доллартай тэнцэж байна. Үүгээрээ Герман улс Монголд хандивлагч хоёр дахь гол орон болж байна.³

Өнөөгийн Монгол-Герман хоёр орны хамтын ажиллагаа дараах салбаруудад эрчимтэй хөгжиж байна. Эдгээр нь:

- Улс төрийн харилцаа
- Эдийн засгийн харилцаа
- Соёл боловсрол, шинжлэх ухааны салбарын харилцаа
- Хөгжлийн хамтын ажиллагаа
- Цэрэг арми, батлан хамгаалах салбарын харилцаа
- Олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаа зэрэг юм.

Хоёр орны хамтын ажиллагаа ийнхүү амжилттай хөгжиж буйн нэгэн тод жишээ нь 2011 оны 10-р сарын 12-13нд ХБНГУ-ын Канцлер Д-р Ангела Меркель Монгол улсад албан ёсны айлчлал хийсэн явдал юм. Энэхүү айлчлал нь ХБНГУ-ын Засгийн газрын тэргүүний хэмжээнд Монгол улсад хийж буй анхны айлчлал гэдгээрээ түүхэн бөгөөд хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд түлхэц үзүүлсэн, хамтын ажиллагааны асуудлуудыг урагшлуулахад чухал ач холбогдолтой болсон бөгөөд Холбооны улсын канцлер айлчлалынхаа явцад Герман улс нь Монгол улсын сайн, найдвартай, тогтвортой түнш байж чадна гэдгийг батлан илэрхийлсний зэрэгцээ Монголын уул уурхай, эдийн засаг, мал аж ахуй, гадаад худалдаа, дэд бүтэц, орон сууц, хот байгуулалтын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, эрүүл мэнд зэрэг салбаруудад хамтран ажиллах тухай хоёр улсын олон чухал гэрээ хэлэлцээрүүдэд гарын үсэг зурсан.

Эдгээр баримт бичгүүдийн нэг нь Монгол улсын БСШУЯ, ХБНГУ-ын боловсрол судалгааны яам хооронд 2003 онд байгуулсан “Шинжлэх ухаан, технологи, боловсролын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн дагуу хамтын үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор хоёр яамны хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай хэлэлцээр байлаа.

³ (Герман улсын Монгол дахь элчин сайдын яамны цахим хуудас http://www.ulan-bator.diplo.de/Yvertretung/ulanbator/mn/05/Entwicklungs_Zusammenarbeit/entwicklungs_zarbeit.html)

Анх 1926 онд Монголын их зохиолч Д.Нацагдорж тэргүүтэй шинэ үеийн сэхээтэн залуусын төлөөлөл сурч боловсрохоор Герман улсыг зорьсноор Монгол Герман хоёр орны боловсрол ШУ-ны салбарт хамтран ажиллах шинэ эрин үеийн эхлэлийг тавьсан гэж үзэж болно.

Манай хоёр орны тус салбар дахь хамтын ажиллагаа нь энэ үеэс өнөөг хүртэл өдрөөс өдөрт улам бүр цэцэглэн хөгжсөөр ирсэн билээ. Өнөөдөр тус хоёр орон нь шинжлэх ухаан, техник, технологи, боловсролын өндөр түвшинд хүүхэд багачууд, оюутан залуус, мэргэжлийн ажилтан болоод техник, технологийн нарийн мэргэжилтэн зэрэг шинээр мэргэжил мэдлэг эзэмших, түүнийгээ дээшлүүлэх, өөрийгөө хөгжүүлэх гэсэн хэн бүхний бодит шаардлагад нийцүүлэн сургалт судалгаа явуулах, туршлага солилцох, шинэ техник, технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт хийх, төсөл хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллаж нийгмийн хөгжил цэцэглэлтэд бодит хувь нэмрээ оруулж байна. Одоогийн байдлаар хоёр орон нь соёл боловсролын салбарт дараах идэвхтэй үйл ажиллагааг явуулж байна. Тухайлбал, герман хэлний сургалт, тэтгэлэгт хөтөлбөр болон санхүүжилт, Германы Эрдмийн солилцооны Алба –(DAAD), Монгол –Германы гүүр ТББ болон их дээд сургуулиудын хамтын ажиллагаа зэрэг юм. Эдгээр чиглэлийн үйл ажиллагааг арай дэлгэрүүлэн үзье.

Герман хэлний сургалт

Улаанбаатар түүнчлэн Дархан, Эрдэнэт, Ховд зэрэг томоохон хотуудад улсын болоод хувийн хэвшлийн их, дээд, дунд сургууль, сургалтын төвүүдэд герман хэлийг анхан, дунд, гүнзгий шатанд болон мэргэжлийн хэлний түвшинд зааж байна. Эдгээрийн сургалт болоод багш оюутан сурагчдыг Германы зүгээс тэтгэлэгт болон солилцоот хөтөлбөрт хамруулах, хөрөнгө оруулалт хийх, зөвлөгөө өгөх, мэргэжилтэн багшаар хангах зэргээр дэмжин ажилладаг.

Үүний зэрэгцээ Улаанбаатар хотноо Германы 100 хувийн хөрөнгө оруулалттай Гетё институт, Мэдээллийн номын сан зэрэг газрууд нь Герман хэлийг сургах, дэлгэрүүлэх, сургалтыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. ШУТИС, ХУИС болон Гетё институт зэрэг газруудад герман хэлний бүх түвшний шалгалт (TestDaf, DSH, DSD, Die zentrale Oberstufenprüfung des Goethe Instituts, Das Kleine oder das Große Deutsche Diplom, Abitur)- ыг авч албан ёсны хүчин төгөлдөр сертификат олгодог. Дойче Веллийн тусламжтай “Deutsches Radio Ulanbator” 98.9 богино долгионы радио үйл ажиллагаа явуулж эхлээд нэлээд удаж байна. Энэ радиогоор “Радио Д” хэмээх герман хэлний сургалтыг цацахаар төлөвлөөд байна.

ХБНГУ-ын Гадаад хэргийн яамнаас хэрэгжүүлж буй “Дунд боловсрол ирээдүйн түнш-санаачлага” (PaSch)-ын хүрээнд манай орны 8 дунд сургууль (нийслэлийн 6, Дарханы 2) Германы дунд сургуулиудтай түншийн харилцаа тогтоон хамтран ажиллаж байна.

Тэтгэлэгт хөтөлбөр болон санхүүжилт

Өнөөдөр Монголд Германы улсын болон хувийн хэвшлийн сан, банк санхүүгийн байгууллага, албадууд болох Германы Эрдмийн солилцооны алба (DAAD), германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Холбооны Гео-шинжлэх ухаан,

ашигт малтмалын газар (BGR), Олон улсын хөгжил, хөдөлгөөний төв (CIM), Германы Хөгжлийн алба (DED), Фрийдрих Эбертийн сан (FES), Ханс Зайделийн сан (HSS), Фрауенхоферын сан (FHS), Гердер Хенкель сан (GHS), Олон улсын давтан сургалт, хөгжил ХХК (Inwent), Сэргээн босголтын зээлийн банк (KfW), Ахмад Мэргэжилтний алба (SES) зэрэг нь өөрсдийн суурин төлөөлөгчийн газраа байгуулан орон даяар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд дараах төрлийн тэтгэлэг болоод санхүүжилт олгож байна. Эдгээр нь:

- Бакалавр, магистр, докторант болон докторын дараах судалгааны тэтгэлэг
- Залуу эрдэмтэнд зориулсан түр болон урт хугацааны судалгааны тэтгэлэг
- Бүх төрлийн шинжлэх ухааны мэргэжлийн чиглэлээр төгсөгчдөд зориулсан дотоод болон гадаадын сургалтын тэтгэлэг
- Уран бүтээлчдэд зориулсан тэтгэлэг
- Дээд курсын оюутнуудад зориулсан дээд сургуулийн зуны курс
- Гадаадын оюутны бүлгүүдийн Герман улсад хийх аялал
- Хөгжиж буй орнуудад хамааралтай сэдвээр дээд түвшинд суралцах
- Тогтвортой хөгжлийн төлөө судлах, суралцах
- Өмнө нь тэтгэлэгт хамрагдаж байсан оюутнуудыг дахин урих тэтгэлэг
- Оюутан болоод эрдэмтдийн солилцооны хөтөлбөрийн тэтгэлэг
- Судалгааны төсөл хэрэгжүүлэх
- Мэргэжлийн ном, сонин, сэтгүүл болоод багаж хэрэгсэл захиалах санхүүжүүлэлт гэх зэрэг юм.

Германы эрдмийн солилцооны алба – (DAAD) (Deutscher Akademischer Austausch Dienst)

Германы эрдмийн солилцооны алба (ГЭСА) нь Германы их, дээд сургуулийн гадаад дахь харилцааг олон улсын хөтөлбөр болон төслийн хүрээнд эрдэмтэд болон оюутан солилцоогоор дэмждэг байгууллага юм. Нийт 100 гаруй улсын 231 их дээд сургууль, 124 оюутны байгууллагатай хамтран ажилладаг⁴.

Монголд одоогоор ГЭСА-ны герман хэлний хоёр багш болон нэг суурин төлөөлөгч багш үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр төлөөлөгч нараар дамжуулж монгол, германы эрдэмтэд болон оюутнуудад зуны сургалт, урт болон богино хугацааны судалгааны ажилд зориулсан тэтгэлгийг олгодог. Тухайлбал 2008 онд Монголын 107, Германы 48 эрдэмтэн, Монголын 69 оюутан, Герман 10 оюутанд тэтгэлэг олгожээ.

Судалгаанаас үзвэл ГЭСА-наас сүүлийн 20 жилийн дотор Монголын их, дээд сургуулиудын 275 багшийг судалгааны ажлаар явуулсан байдаг. Үүний 94 нь буюу 34 хувь нь зөвхөн МУИС-ийн багш нар байгаа юм байна. ГЭСА нь шинжлэх ухааны бүх салбарт ижил түвшний боломж олгодог. Сонголтын хамрах хүрээ, чиглэл чөлөөтэй, илүү өргөн хэмжээнд боломж өгдгөөрөө тодорхой нэг сан, хувь хүн, байгууллагын тэтгэлгээс давуу талтай. Тухайлбал, Фрауенхоферын сан зөвхөн техникийн, Конрад Аденауерын сан зөвхөн хууль зүй, улс төрийн, Гердер Хенкель сан зөвхөн археологийн салбарт тэтгэлэг олгодог. Тэгвэл манай алба байгаль, нийгмийн шинжлэлийн бүх салбарыг хамарч байна⁵.

⁴ www.must.edu.mn

⁵ Ральф Герхард Хаймрат: ГЭСА нь бүх мэргэжил чиглэлд тэгш боломж олгодоггоороо онцлогтой, <http://news.num.edu.mn/?p=3203>

МУ-ын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг ХБНГУ-д айлчлах үеэр ГЭСА (DAAD)-ны ерөнхий нарийн бичгийн дарга Х.Руланд ерөнхийлөгчид Монгол улстай хэрэгжүүлж буй боловсролын салбар дахь хамтын ажиллагааны талаар мэдээлэл өгч, Герман улсад Монголоос мастер, докторын зэрэг хамгаалахыг түлхүү дэмжиж байгаагаа илэрхийлсэн байна.

Үүний зэрэгцээгээр 2010 оноос эхлэн ГЭСА нь Монголын БСШУЯ-тай хамтран уул уурхайн салбарт ажиллах мэргэжилтэн бэлтгэхтэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх болсон бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд жил бүр 10 бакалавр, 10 магистрын тэтгэлэг олгох болсон юм.

"Монгол – Германы гүүр" ТББ

"Монгол-Германы гүүр" ТББ бол Германы их, дээд сургуулиудад суралцагчид, төгсөгчид, эх орондоо эргэн ирэгсэд болон тэдний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилготойгоор германд төгсөгчдийн санаачилгаар байгуулагдсан ашгийн бус байгууллага юм. Эх орондоо эргэн ирэгсэд болон Германд байгаа оюутанд нийгмийн байр сууриа дахин олоход дэмжлэг үзүүлэх зорилгоор мэргэжлийн зөвлөгөө өгөх, ажлын байр зуучлах, мэдээлэл өгөх гэх мэтийн хэлбэрээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Үүнд төсөл хэрэгжүүлэх, сургалт семинар явуулах, үзэсгэлэн яармаг ба хөдөлмөрийн бирж зохион байгуулах, монгол герман хэлнээс орчуулга хийх зэргийг дурьдаж болно. ХБНГУ-ын түнш байгууллагуудын дэмжлэгээр эргэн ирэгсэд болон оюутнуудад мэргэжлээрээ эх орондоо байр сууриа олоход зориулсан зөвлөгөө, дэмжлэгийн арга хэмжээ болон бусад үйл ажиллагааг Монголд болон Германд тогтмол явуулдаг. Монгол-Германы гүүрний ТББ-ын Герман дахь түнш байгууллагууд нь Олон улсын шилжих хөдөлгөөн, хөгжлийн байгууллага (СИМ), Германы үндэсний ба гадаадын мэргэжилтнүүдийг зуучлах төв (ZAY), Берлин дэх хөгжил, хамтын ажиллагааны байгууллага (AGEF), Дэлхийн их, дээд сургуулиудад үйлчлэх байгууллага (WUS), Хүмүүнлэгийн тусламжийн байгууллага (Misereor), Лайпциг хотын Их сургууль, Герман-Монголын соёлын нийгэмлэг зэрэг юм.

Их дээд сургуулиудын хамтын ажиллагаа

XXI зуунд их дээд сургуулиуд нь зөвхөн сургалт явуулах төдий биш харин судалгааны чиглэлд илүү түлхүү анхаарч сургалтаа эрдэм шинжилгээ, судалгаанд суурилан явуулах глобал чиг хандлагатай болоод байгааг эрдэмтэд тодорхойлсон байдаг. Манай орны сургуулиуд ч мөн өнөөгийн энэхүү бодит шаардлагыг үйл ажиллагааныхаа стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Дэлхий нийтээрээ даяаршиж буй энэ эрин үед их, дээд сургуулиудын гадаад харилцаа, хамтын ажиллагаа нь тэдгээрийн олон талт үйл ажиллагааны хамгийн гол хэсгийн нэг болох нь маргаангүй билээ.

2009-2010 оны хичээлийн жилийн байдлаар Монгол улсад 146 их, дээд сургууль, коллеж, үүнээс төрийн өмчийн 42, төрийн бус өмчийн 99, гадаадын 5 сургууль үйл ажиллагаа явуулж байна хэмээн бүртгэгдсэн байна⁶.

⁶ <http://www.mecs.gov.mn/article-398-435.mw>

Тус сургуулиуд нь дор бүрнээ гадаад харилцаагаа өргөтгөн бусад орны нэр хүнд бүхий сургуулиудтай түншийн харилцаа тогтоохыг чармайн ажиллаж байна. Гадаад орны дараах эдгээр сургуулиудын тоонд Германы их, дээд сургуулиуд зүй ёсоор ордог. Тухайлбал манай орны томоохон сургуулиудыг нэрлэж болно.

- МУИС нь гадаадын 129 их сургуультай хамтын ажиллагаатай бөгөөд үүнээс Германы Берлиний Чөлөөт их сургууль, Гумбольдтын их сургууль, Гёттингений их сургууль, Мюнхений их сургууль, Халлегийн их сургууль, Касселийн их сургууль, Макс Планкийн хүрээлэнгийн Химийн их сургууль, Байротын их сургууль, Бранденбургийн их сургууль зэрэг 10 орчим сургуультай (www.num.edu.mn);
- ХААИС нь 25 орны 60 гаруй их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажилладагаас Германы Вайнштепаны их сургууль, Лайфцикийн их сургууль, Берлиний их сургууль зэрэг сургуулиудтай⁷,
- ШУТИС нь гадаадын 110 орчим сургуультай хамтын гэрээтэй байгаагаас 10 гаруй нь Германы сургуулиуд байна. Эдгээр нь Ханноверийн Дизайны дээд сургууль, Дармштатийн Техникийн их сургууль, Дрездены Техникийн их сургууль, Фрайбергийн Бергакадемийн их сургууль, Оснобрукийн их сургууль, Метгвайдагийн Хавсрал ШУ-ны ИС зэрэг байна.

Монгол, Германы их сургуулиуд нь хамтын ажиллагааны олон жилийн түүхтэй бөгөөд тус ажиллагааныхаа хүрээнд багш, оюутан солилцох, зочин болон судлаач багш ажиллуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, судалгааны суурин төлөөлөгч ажиллуулах, техник, тоног төхөөрөмжөөр хангах, ЭШ-ний хамтарсан хурал, семинар зохиох, соёл хоорондын харилцаа тогтоох, зуучлахад үйлчлэх, сургалтын төлөвлөгөө боловсруулах, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр сургалт, судалгааны бүхий л чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал МУИС нь Германы их сургуулиудтай байгаль хамгаалал, экологи, биологи, археологи зэрэг байгалийн ухааны чиглэлээр илүү хамтран ажиллаж байна.

Дүгнэлт

- Эдүгээ 800 шахам жилийн түүхтэй Монгол, Герман хоёр орны харилцаа даяаршлын өнөөгийн эрин үед иж бүрэн түншлэлийн хүрээнд улам бүр өргөжин тэлсээр байна.
- ХБНГУ нь Монгол улсын гуравдагч хөрш бөгөөд Европ дахь хамгийн гол түнш орон юм.
- Герман улс нь Монгол Улсад техник болон санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд үзүүлж буй тусламж дэмжлэгийн хэмжээгээрээ Монголд хандивлагч хоёр дахь гол орон болж байна.
- Монгол, Герман хоёр орон нь улс төр, эдийн засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллахын зэрэгцээ цэрэг арми, батлан хамгаалах болон олон улсын энхийг сахиулах үйл ажиллагаанд ч хамтран ажиллаж байна.
- Сүүлийн жилүүдэд Монгол Германы төрийн тэргүүд болон засгийн газрын төлөөлөгчид харилцан айлчлал хийж байгаа нь хоёр орны харилцааны хөгжилт

⁷ http://www.msua.edu.mn/view_news1.php?sub=94

цэцэглэлтэнд их хувь нэмэр болж байна.

- Өнөөдөр Монголд Германы улсын болон хувийн хэвшлийн нэлээд олон сан, банк санхүүгийн байгууллага, албадууд орон даяар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд манай орны хүүхэд, залуус, эрдэмтэн, судлаачдыг дэмжин олон төрлийн тэтгэлэг болоод санхүүжилт олгож байна.
- ГЭСА нь олгож буй тэтгэлгийн хэмжээ, төсөл болоод бусад арга хэмжээ зэргийг санхүүжүүлж буй байдлаараа эрдэм шинжилгээ, судалгааны салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийж буй газруудын нэг юм.
- Монгол орон нь байгалийн нөөц баялгаар баян, харин Герман орон нь техник, технологийнхоо дэвшлээр тэргүүлэгч орнуудын нэг бөгөөд тус хоёр орны хувьд цаашид олон чиглэлээр хамтран ажиллах өргөн бололцоо байна.
- Монгол, Германы улсын болоод хувийн байгууллагууд, нэгж сангуудын хамтран хэрэгжүүлж буй өргөн хүрээт үйл ажиллагаа, олон жилийн хамтын ажиллагааны ололт амжилтуудыг нэг өгүүллийн хүрээнд бүрэн авч үзэх боломжгүй билээ. Иймд хоёр орны хамтын ажиллагааны асуудлыг тодорхой нэгэн салбарын хүрээнд нь авч үзэн судалгаа хийх нь маш сонирхолтой бөгөөд хоёр орны хойшдын хамтын ажиллагааны чиг хандлага, зорилго, зорилтуудыг тодорхойлоход ашиг тустай ажил болох тул энэ талаар цаашид гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

Баркманн, У.,	ХБНГУ ба Монгол улсын хооронд байгуулагдсан гэрээ хэлэлцээрүүд, 2005
Буянтөгс, А.,	Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчин, "Олон улс судлал" сэтгүүл, 2004, №3
Хайсандай, Л.,	Баркманн, У., Монгол-Германы харилцаа: Өнгөрсөн үе – эдүгээ-хэтийн төлөв
Жамц, Р.,	Богд хаант Монгол улс, БНМАУ-аас Германтай харилцаа тогтоох гэсэн оролдлогууд ба Германд анх монгол иргэд сургаж эхэлсэн нь, "Олон улс судлал" сэтгүүл, 2003, №1
Жамц, Р., Төрдалай, Р., Лхам, Ц.,	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, 2011
	ХБНГУ-ын эдийн засгийн байдал ба Монгол-Германы хамтын ажиллагаа, "Олон улс судлал" сэтгүүл 2003 №4

Цахим эх сурвалжууд

www.bundespraesident.de
www.bundesregierung.de
https://dgap.org/de
http://www.fes.de
http://www.goethe.de
http://www.mdb.mn
http://www.mecs.goy.mn
www.mines.edu.mn

http://www.mongolei.de
http://www.mongolei-zentrum.de
http://www.msua.edu.mn
www.must.edu.mn
http://www.num.edu.mn
http://www.politics.news.mn
www.president.mn
http://www.ulan-bator.diplo.de